

Сэйд Гойда (Египт/Хонг Конг)



Sayed Guoda
(Egypt/Hong Kong)

Эрвээхэй

Butterfly

Миний зүрх сэтгэл бол уулсаар хүрээлэгдсэн
нэгэн эрвээхэй юм.

Тэр эрвээхэй тэнгэрт дуртай
Тэгэхдээ борооноос айдаг
Хойд зүгийн анхилам үнэртэй
дотно нэгэн цэцэгийг хүсдэг
хөөрхийдөө түүнийгээ үргэлж дагадаг
хэрвээ салхины төлөө биш бол
шөнө...

уул...
бас нөгөө бороо...

Хойд зүгийн анхилам үнэртэй
дотно цэцэг нэг нууранд хөвдөг
Орь ганцаархнаа шөнө болгон
Оддыг хүлээж сэрүүн хонодог
Нээрээ тэднийг хүлээдэг, түүн шиг
Түүний од тэнд
миний од энд биш үү?

translated by Mugi

